



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 5/65

Жавхлант

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.3, 19.2.4, 19.3.3, 19.3.4, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэрхаан багийн “Харган толгой” гэх газарт нутаглаж байгаа малчин Ц.Алтансүхийн суурийн хонинд Хэнтий аймгийн мал эмнэлгийн лабораторийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн 25-101 дугаар бүхий шинжилгээний хариугаар дотрын халдварт хордлого өвчин гарсан болох нь батлагдсан тул 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Дотрын халдварт хордлого өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг чанартай зохион байгуулж ажиллахыг “Эх цаг” хариуцлагатай хувьцаат компани захирал (Ч.Нацаг)-т үүрэг болгосугай

3.Тухайн багийн нутаг дэвсгэрт мал, малын гаралтай түүхий эд болон малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар), багийн Засаг дарга (Х.Энх-уянга) нарт үүрэг болгосугай.

5.Шаардлагатай эм бэлдмэл, ариутгалын бодис, холбогдох газруудад мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн Тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТЧУЛУУН

D:Zasag darga /zahiramj-2025/